

ЗҮҮН ХОЙД АЗИ БА МОНГОЛЫН ГАДААД БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛ

С.Мөнхбат Доктор, дэд профессор
МУИС, НШУС-ийн дэд захирал

Key words : Northeast Asia, foreign policy, political and economic foreign policy, third neighbor and partnership, resources of energy, based on natural resources policy toward Asian region, present situation and perspectives in Northeast Asia.

Монгол улсын гадаад орчин ба гадаад бодлогын үзэл баримтлал.

Монгол нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, ардчилсан ёс, хүний эрх эрх чөлөөг дээдэлсэн, чөлөөт эдийн засгийн тогтолцоотой, хөгжиж буй улс бөгөөд газарзүйн байрлалын хувьд Ази тивд хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй орон юм. Хоёр хөрш болох ОХУ, БНХАУ нь Монголоос газар нутгийн хэмжээ, хүн амын тоо болон эдийн засгийн чадавхаараа хэдэн арав дахин том их гүрнүүд. Олон зуун жилийн турш геополитикийн бодлогын хүрээгээ тэлж ирсэн дэлхий дахинд нөлөө бүхий хоёр эл гүрэн далайд гарцгүй, дотоод хүчин чадал сул Монголчууд бидний түүх, соёл, зан заншил, хөгжил дэвшлийн бүхий л хүрээнд олон талаараа шууд ба дам нөлөө үзүүлж, эгзэгтэй үед Монголын хувь заяаг тусдаа хийгээд хамсан нийлж шийдвэрлэж байсан¹¹⁰ цаг үеүдийг түүхээс бид мэдэх билээ.

Хөрш хоёр их гүрнээс цааш бүс нутгийн хэмжээнд авч үзвэл манай улс Азийн цээжинд байрласан эх газрын орон бөгөөд газарзүй, геополитикийн үүднээс авч үзвэл Монгол нь Зүүн Хойд Ази, Төв Азийн аль алинд нь хамаарахаар байрлалтай. Үүнийг улс төр судлаачид, түүхчид, эдийн засагчид, газар зүйчид санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрдөг. Эндээс миний бие Зүүн Хойд Азийн бүсэд Монголын хамаарах хамаарал, явуулж буй улс төрийн бодлогын талыг хөндөн тодруулахыг эрмэлзсэн болно.

XX зууны 90-ээд оны дэлхий нийтийг хамарсан өөрчлөлт шинэчлэлтийн үр дүнд энэ бүсэд хамаарах улс орнууд, ялангуяа их гүрнүүд харилцаагаа аль болох хэвийн болгож, сөргөлдөөний байдлаас гарч, итгэлцэлд тулгуурласан идэвхтэй хамтын үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм. Энэхүү хоёр талын болон олон талын харилцан үйлдлийн явцад “Зүүн Хойд Азийн бүс нутаг” гэдэг томъёолол дэлхийн улс төр-эдийн засгийн хэллэгт байр сууриа эзлэх болсон байдаг. Азийн хуурай газрын 20 хувь нь ноогдох энэ бүс нутагт Дорнод Сибирь, Алс Дорнод, Солонгосын хойг, Японы арлууд, Монголын зүүн бүс, Манжуур багтдаг¹¹¹. Өөрөөр

¹¹⁰ Д.Уламбаяр. Монгол улсын гадаад бодлого дахь гуравдахь хөрш буюу түншлэлийн асуудалд. Стратеги судлал сэтгүүл №46 (2/2009).УБ. 74 дэх тал

¹¹¹ Л.Хайсандай. Монгол улсын хөгжлийн бодлого ба Зүүн Хойд Азийн үүрэг. Стратеги судлал сэтгүүл. №45 (1/2009)., УБ. 133 дахь тал

хэлбэл ОХУ, Монгол, Хятад, Япон, БНСУ, БНАСАУ (АНУ газарзүйн хувьд харьяалагдахгүй ч бүс нутагт үзүүлдэг нөлөөгөөр нь судлаачид хамруулж үзэх тал бий¹¹²) гэсэн зургаан орны тодорхой нутагууд орж байгаа бөгөөд Азийн хүн амын 10 орчим хувь буюу 300 сая гаруй хүн энэ бүс нутагт амьдарч байгаа нь Европын холбооны дайтай том зах зээл, том орон зай гэсэн үг. Хэдий ийм том бүс нутаг боловч улс төр, эдийн засаг, соёлын зэрэг олон хүчин зүйлсийн хувьд Зүүн Хойд Ази нэгдсэн интеграцид орж харилцан бие биенээ тэтгэн хөгжүүлэх хүчин зүйлүүд бүрдэх үйл явц удаашралтай байна.

Энэ бүс нутагт эдийн засгаараа дэлхийд тэргүүлэгч АНУ, Япон, БНСУ хамгийн хоцрогдмол эдийн засагтай БНАСАУ, хамгийн хурдацтай хөгжиж буй эдийн засагтай БНХАУ, мөн шилжилтийн эдийн засагтай ОХУ, Монгол, гээд бүс нутаг дотроо олон хэлбэрийг агуулж, тэгш бүс эдийн засгийн харилцаа үүсгэх сөрөг тал бас бий.

Улс төрийн хувьд капиталист, социалист улс төрийн дэглэм төвлөрсөн, хүйтэн дайны сүүлийн үлдэгдэл газар гэж үзэж болно. Нэг талаас АНУ, Япон, Өмнөд Солонгосын капитализм, нөгөө талаас БНХАУ, Хойд Солонгосын социализм, мөн түүнчлэн шилжилтийн үе шатандаа яваа ОХУ, Монголын улс төр, ардчиллын загварууд хөгжиж байна.

Иргэншлийн хувьд ерөнхийдөө кунзийн үзэл суртал давамгайлсан шинжтэй байгаа бөгөөд Япон, Синик буюу Хятад, Буддын, Христ, Ортодоксын гээд хэд хэдэн том соёл иргэншлүүд зэрэгцэн оршдог бол цэрэг-стратегийн хүчин чадлын хувьд хүчирхэг арми бүхий АНУ, ОХУ, БНХАУ, Хойд Солонгос оршиж байна.

Ийнхүү Зүүн Хойд Ази бол эдийн засгийн тогтолцоо, улс төрийн дэглэм, цэрэг армийн төвлөрөл, соёлын хүчин зүйлүүдийн холимог болсон, эрс тэс ялгаатай, ээдрээ төвөгтэй гэж тодорхойлж болох ерөнхий суурь дэвсгэртэй бүс нутаг билээ.

Зүүн Хойд Ази ба Монгол улс

Зүүн Хойд Ази руу чиглэсэн Монгол улсын гадаад бодлого нь гуравдагч хүчний ашиг сонирхолыг бий болгох, дэд бүтэц тэр дундаа уул уурхайн салбар эрчимтэй хөгжих нөхцөл бүрдэж түүнд байгальд ээлтэй өндөр технологийг нэвтрүүлэх эрэлт хэрэгцээ үүсэж байгаа зэрэгтэй уялдан сүүлийн жилүүдэд идэвхжиж байна. Бүс нутгийн орнуудын зүгээс ч Монголд хөрөнгө оруулах, хамтарсан томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, тогтвортой хамтын ажиллагааг өрнүүлэх талаар санал, санаачлагыг гаргаж байгаа нь энэ бүс нутгийн улс төр, эдийн засгийн интеграцид улам бүр нэгдэн нягтрах боломжийг нээж байгаа билээ. Монгол улсын гадаад бодлого ч энэ бүс нутгийн улс төр, эдийн засгийн интеграцид нэгдэж, Зүүн хойд азийн зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүнээ нийлүүлэх талаар

¹¹² Ц.Даваадорж, Б.Индра. Монгол улс ба Зүүн Хойд Азийн эрчим хүчний хамтын ажиллагаа. Стратеги судлал сэтгүүл. №48 (4/2009)., УБ. 7 дахь тал

ихээхэн чармайлт гарган ажиллаж байна. Үүнийгээ ч гадаад бодлогынхоо үзэл баримтлалд тодорхойлсон.

Тэрээр Монгол улс гадаад бодлогынхоо зорилтыг “хүн төрөлхтний хөгжлийн жамыг даган бүх улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэн, бүс нутгийн болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцааны сүлжээ бүрдүүлэх замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах явдал”¹¹³ гэж тунхагласан. Монгол улс нь эвсэлд үл нэгдэх нээлттэй бодлого явуулдаг орон. Монгол улсын гадаад бодлого нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан технологи, соёл, хүмүүнлэгийн гэсэн дөрвөн гол чиглэлээр хөгжиж байна.

Улс төрийн гадаад бодлого. Монголын улс төрийн гадаад бодлого нь улсын аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх нэг гол хэрэглүүр бөгөөд түүний үр дүнг юуны өмнө тус улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолын ашиг сонирхол хэрхэн хангагдаж, олон улсад байр суурь нь хэр бэхжиж, нэр хүнд нь хэрхэн өсч байгаагаар тодорхойлдог. Хөрш хоёр их гүрэнтэйгээ найрсаг хамтын харилцааг хөгжүүлэх нь Монгол улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл мөн.

Монгол улсын гадаад улс төрийн бодлогын хоёр дахь чиглэл нь АНУ, Япон, Герман зэрэг өрнөдийн хөгжингүй орнуудтай найрсаг, харилцан ашигтай хамтын харилцааг хөгжүүлэхэд чиглэж ирсэн юм.

Монгол улсын гадаад улс төрийн бодлогын гурав дахь чиглэл бол оршин буй Азийн бүс нутагт байр сууриа бататгаж Азийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал гэж үздэг. Энэ зорилтын хүрээнд Ази, Номхон далайн чиглэл, түүний дотор Зүүн-Хойд Азийн улс төр, эдийн засгийн бодлогод түлхүү анхаарч, оролцож ирсэн цаашид оролцоох оролцоогоо нэмэгдүүлэх талаар анхааран ажиллах явдал чухлаар тавигдаж байна.

Эдийн засгийн гадаад бодлого. Монгол улсын эдийн засгийн гадаад бодлогын үндсэн зорилго нь улсын эдийн засгийн хэтийн болон цаг үеийн зорилтыг зохистой шийдвэрлэхэд гадаад хүчин зүйлийг оновчтой ашиглах, улмаар улс орны эдийн засгийг бүс нутгийн интеграцид өөрийн гэсэн байр суурьтай болгоход оршино¹¹⁴. Экспортод чиглэсэн үйлдвэрүүдийг хөгжүүлэх үндсэн дээр түлш, эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам тээврийн таатай нөхцөл бүрдүүлэх ялангуяа Зүүн Хойд Азийн зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл, харилцаа, холбооны сүлжээнд нэгдэж орох явдал нэн чухал гэж үзэн энэ чиглэлийн бодлого боловсруулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Шинжлэх ухаан технологийн гадаад бодлого. Шинжлэх ухаан технологийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны гол зорилго нь улс орны эдийн засаг,

¹¹³ Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал. УБ хот

¹¹⁴ Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал. УБ хот

үйлдвэрлэлийн хөдөлгөгч хүч үндэсний шинжлэх ухаан техник, технологийн орчин үеийн чадавхийг бүрдүүлж хөгжүүлэхэд гадаад хүчин зүйлийг бүрэн ашиглахад оршиж байна.

Соёл, хүмүүнлэгийн гадаад бодлого. Соёл хүмүүнлэгийн гадаад бодлогын гол зорилго нь монгол туургатны соёл иргэншлийг хамгаалан арвижуулах, дэлхийн соёлын нийтлэг ололтоор баяжуулах, Монгол улсыг сонирхогч, талархагчдын эгнээг өргөтгөх, бусад орон дахь Монгол судлалыг хөхүүлэн дэмжих, улс түмнийг танин мэдэх, тэдэнтэй харилцан ойлголцох, итгэлцэх явдлыг нэмэгдүүлэхэд оршиж байгаа юм.

Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын дээрх чиглэлүүд нь дэлхийд нээлттэй гадаад улс төр, эдийн засгийн бодлого явуулах зорилго зорилтыг тодорхойлж, Монголын улс дэлхий дахины хөгжлийн ололт амжилтаас суралцаж хөгжил, дэвшилд хүрэх нааштай алхамууд гэж дүгнэж болох юм.

Зүүн Хойд Ази яагаад Монголын улс төр, эдийн засгийн түшиг тулгуур болж ирсэн бэ?

Газарзүй, геополитикийн үүднээс авч үзвэл Монгол нь Зүүн Хойд Ази, Төв Азийн аль алинд нь хамаарч болохоор байршилтай, түүхнээ судлаачид, газарзүйчид Монголыг аль алинд нь оруулж тооцож ирсэн байдаг¹¹⁵. Соёл иргэншил талаас нь авч үзвэл гурван соёл иргэншлийн зааг дээр оршиж ирснээрээ онцлогтой. Хойгуураа Христосын ортодокс- үнэн алдартны шашин бүхий ОХУ-тай, урдуураа Күнзийн суртал бүхий Хятадтай, баруун талаараа Казахстан болон Төв Азийн бусад улсуудтай дөхүү байршилтай ба мөн лалын шашинт нэг аймагтайн хувьд лалын хөрштэй гэж үзэж болно.

Улс төр, эдийн засгийн хувьд Монгол нь 70 жил Зөвлөлтийн дагуул орон байж ирсэн бөгөөд “хүйтэн дайн”-ы жилүүдэд социалист хамтын нөхөрлөлийн дорнод жигүүрт тооцогдож, Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл (ЭЗХТЗ)-ийн гишүүн, өөрөөр хэлбэл хойшоо, баруун хойшоо чиглэсэн л бодлогтой явж ирсэн юм¹¹⁶.

1990 онд социалист систем бүхэлдээ нуран унасанаар тэрхүү системд багтаж байсан Монголд гадаад талдаа түшиц болох улс орон байхгүй байсан бөгөөд Азийн бүс нутаг тэр дундаа Зүүн Хойд Ази руу чиглэсэн идэвхтэй гадаад бодлогыг энэ үеэс явуулж эхэлсэн юм. Тухайн үед Монголын ардчилсан шилжилтийг талархан хүлээн авч дэмжих цорын ганц найдлага Зүүн Хойд Ази буюу тэр дундаа энэ бүс нутагт хамаарах Япон улс байсан юм. ЗХУ задарсан учир Монголыг анхаарах нь бүү хэл дотооддоо гүн хямралтай байсан юм. Хятад улс

¹¹⁵ Д.Баярхүү. Евразийн геополитик, олон улсын харилцаа: өнгөрсөн, одоо, ирээдүй. УБ., 2005. 133 дахь тал

¹¹⁶ Д.Баярхүү. Евразийн геополитик, олон улсын харилцаа: өнгөрсөн, одоо, ирээдүй. УБ., 2005.

133 дахь тал

коммунист дэглэмтэй (одоо ч улс төрийн хүрээнд авторитари) байсан төдийгүй Хятадууд эртнээс Монголчуудад таагүй хандаж ирсэн учир Монголчууд тэдэн рүү хандах ямар ч сонирхол байгаагүй нь тухайн үеийн улс төрийн үйл явцаас тодорхой харагддаг. Тяньмэний талбайд болсон оюутан, залуучуудын хөдөлгөөнийг нухчин дарсан явдал Хятад улсын нэр хүндийг олон улсад унагасан үйл явдал байсан бөгөөд Монгол энэ үйл явдлын эсрэг байр суурьтай байсан нь цаашид ардчилсан шинэчлэлээ дэмжүүлэх бус харин хамгаалж үлдэх явдал амин чухал асуудал байсан юм. Хятад руу хандлаа гэхэд Оросын коммунизмыг Хятадын коммунизмаар солих тавилан хүлээж байсан нь эргэлзээгүй юм.

1990-ээд онд Монголын ардчилал, шинэчлэлийг Солонгосын тал анхааралтай ажиглаж байсан юм. Энэ үед Ро Дэ У-ийн засаг захиргаа улс төрийн дэглэмийн хувьд төдийлөн ардчилсан байгаагүй ч харьцангуй тайван, ардчиллын үндэс суурийг нийгмийн бүхий л салбарт бэхжүүлсэн байсан юм. Солонгос улс Монгол дахь 1990 оны ардчилсан өөрчлөлтийг эхнээс нь дэмжиж ирсэн бөгөөд зах зээлийн эдийн засгийн хүндрэлийг даван туулахад идэвхтэй дэмжлэг үзүүлсээр байгаа. Баруун Европын улсуудын тухайд алс Монголын асуудлаас илүүтэй хил залгаа Зүүн Европын орнуудын ардчилсан шилжилт, түүнийг даван туулах асуудалд анхаарал хандуулж, бодлогоо чиглүүлж байв.

Энэ бүхнээс үзэхэд 1990 онд социалист систем нурсаны дараа Монголд түшиг болж чдаха цорын ганц бүс нь Зүүн Хойд Ази байсан нь тодорхой байна. Өмнө дурьдсанчилан Монголтой хил залгаа улсуудад улс төрийн дэглэм, улс төрийн ардчилсан шилжилт, дотоод асуудлуудаасаа болоод Монголын ардчилал, шинэчлэлтийг дэмжих, түшиц болох улс байгаагүй юм. Ийм нөхцөлд Монгол улс ардчилсан шилжилтээ цаашид гүнзгийрүүлж хөгжүүлэх үүднээс бүх талын дэмжлэг үзүүлж чадах улс орныг эрэлхийлсэн бөгөөд АНУ, Япон, Баруун Европын хөгжингүй орнуудад хандсан байдаг.

Эдгээрээс газарзүйн байрлал, бүс нутгийн соёл, эдийн засгийн нөөц боломж зэрэг олон үзүүлэлтээр Зүүн Хойд Азид бодлого тодорхойлоход нөлөө бүхий Япон улс 1991 онд Монголын ардчилал, шинэчлэлийг хоёр талын харилцааны хүрээнд болон олон улсын хэмжээнд дэмжихээ зарласан нь Монгол улс Япон улстай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх зорилтыг гадаад бодлогынхоо тэргүүлэх чиглэлийн нэг болгох түүхэн үүргийг Монголын үе үеийн төр, засгийн тэргүүнүүдэд ноогдуулж тэд ч бодлого, үйл ажиллагааныхаа хөтөлбөртөө тусган ажиллаж ирсэн.

1998 онд Монгол улсын Ерөнхийлөгч Япон улсад айлчлал хийж “Найрамдал хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл”-д хоёр орны харилцааг иж бүрэн түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх зарчмыг зарласан. Монгол улсын Ерөнхийлөгч 1998, 2003, 2006, 2010 онуудад, Ерөнхий сайд 1992, 1994, 1997, 2001, 2006, 2009, 2010 онуудад, УИХ-ын дарга 1994, 1999, 2002 онуудад тус тус ажлын айлчлал хийсэн бол Японы талаас Ерөнхий сайд 1991, 1999 онуудад, парламентын дарга 1995, 1997 онуудад тус тус айлчилсан байна. Эндээс үзэхэд Монголын гадаад

бодлогын тэргүүлэх улс нь Япон улс мөн бөгөөд цаашид ч энэ байдал үргэлжлэн хөгжих боломж улам бүрэн нээгдсээр байна.

Өнгөрсөн 2010 оны 11-р сарын 15-19-ний өдрүүдэд Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Япон улсад төрийн айлчлал хийж Япон улсын ерөнхий сайд Нато Кантай хоёр орны харилцааг “стратегич”-ийн түвшинд хөгжүүлэх хамтарсан мэдэлдэлд гарын үсэг зурлаа. Хамтарсан мэдэгдэлд **а.** Хоёр орны өндөр дээд хэмжээний яриа, хэлэлцээрийг идэвхжүүлэх, **б.** Эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх, **в.** Хүн болон соёлын солилцоо, харилцааг идэвхжүүлэх, **г.** Бүс нутаг, глобал асуудлаарх хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг асуудлуудад онцгой ач холбогдол өгч хамтарч ажиллахаар тохиролцсон байна.

Япон улс нь зээл тусламжийн нэг хүнд ноогдох хэмжээгээр Монгол улс тэргүүлж байна. 1991-2008 оны байдлаар буцалтгүй тусламж 863.12 мл, хөнгөлөлттэй зээл 679.14 мл, техник хамтын ажиллагаанд 305.11 мл төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

Зүүн Хойд Азийн улс төр, эдийн засгийн бодлогод нөлөө бүхий Хятад, Солонгосын байр суурийг Монголын тал хүндэтгэн үзэн харилцаж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж байгаатай холбоотойгоор хөрш орнууд, Монголын уул, уурхайн ордуудыг сонирхогч гуравдагч орнууд, томоохон пүүс, компаниудын тоо эрс өсч байна. Энэ хэрээр Монголд орох гадаадын хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж гуравдагч хөршийн улс төр, эдийн засгийн бодит сонирхол Монголд бий болж эхэлсэн нь Монголын гадаад бодлогод чухал ахиц гарч буйн тод илрэл болж байна. Уул уурхайн төслүүдийг эрчимжүүлэх бодлогын хүрээнд ОХУ, Япон, Солонгос, БНХАУ зэрэг Зүүн Хойд Азийн улсуудтай хамтарч ажиллах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өндөр технологийг нэвтрүүлэх асуудлыг Монголын тал анхааран судалж зарим төслүүд дээр хамтарч ажиллах гэрээ, хэлэлцээрийг байгуулаад байна.

Зүүн Хойд Ази ба Монголын байгалийн баялаг

Дэлхийд нүүрсний хамгийн том импортлогчид Зүүн Хойд Азид бий. 2009 онд дэлхийн хамгийн их нүүрс импортолсон гурван улс Япон, БНСУ, Хятад байв. Харин экспортлогчоор Орос гуравт, Хятад долоод¹¹⁷ жагссан байна. Өөрөөр хэлбэл энэ бүс нутагт том хэрэглэгчид ч, том нийлүүлэгчид ч байна. 2006-2030 оны хооронд дэлхийн нүүрсний хэрэглээ 49 хувиар нэмэгдэнэ¹¹⁸ гэсэн тооцоо байна.

Байгалийн нөөц ашиглалт, хэрэглээ болон экспорт, импортын хэмжээг Зүүн Хойд Азийн бүсд хамаарах ОХУ, Япон, Хятад, Өмнөд Солонгос улсуудын жишээн дээр харьцуулан тайлбарлая.

Хүснэгт.1

¹¹⁷ <http://www.worldcoal.org/resources/coal-statistics>

¹¹⁸ International Energy Outlook 2009. <http://eia.doe.gov/oiaf/ieo/coal.html>

Д. д	Байгалий н нөөц	ОХУ	Хятад	Япон	Өмнөд Солонгос
1	Нүүрс	173 тэрбум нүүрсний нөөцтэй. Дэлхийн нүүрсний нөөцийн 18.5 хувийг эзлэх бөгөөд дэлхийд 2-т орно. ОХУ 2007 онд 345 сая тонн нүүрс олборлож, 101 сая тонныг экспортолжээ ¹¹⁹ . 2020 он гэхэд 441-496 сая тонн нүүрс үйлдвэрлэх тооцоотой ¹²⁰ .	114.5 тэр бум тонн нүүрсний нөөцтэй. Дэлхийн нүүрсний нөөцийн 13.5 хувь болж дэлхийд 3-т орж байна. 2008 онд 3 тэрбум орчим нүүрс хэрэглэсэн нь дэлхийн хэрэглээний 40 орчим хувь болж байгаа бөгөөд 2000 оныхоос даруй 129 хувиар нэмэгдсэн ¹²¹ байна. Хятадын нүүрсний хэрэглээ 2010 онд 3 тэрбумаас давж, 2020 он гэхэд 3.4 тэрбум тонн болно гэсэн тооцоо байна.	Дэлхийн хамгийн том нүүрс импортлогч орон. 2008 онд 191.7 сая тонн нүүрс импортолж, өмнөх оноосоо 2.8 хувиар нэмэгджээ ¹²² . Голдуу Австрали, АНУ, Хятад, Өмнөд Америк, Оросоос импортолдог.	Дэлхийн хоёрдогч нүүрс импортлогч орон. 2008 онд 82 сая тонн нүүрс импортлохоор тооцож байсан ч 100 сая тонныг импортолсон ¹²³ байна. Импортынхоо 70 хувийг Австрали, Хятадаас оруулдаг байна.

¹¹⁹ http://www.tonto.eia.doe.gov/country/_time_series.cfm?fips=RS

¹²⁰ <http://www.eia.doe.gov/emeu/cabs/Russia/Full.html>

¹²¹ <http://www.eia.doe.gov/emeu/cabs/China/Full.html>

¹²² <http://en.sxcoal.com/newsdetail.aspx?catellID>

¹²³ <http://www.worldcoal.org/resources/coal-statistics>

2	Газрын тос	60тэрбум баррель газрын тосны нөөцийн ихэнх нь баруун сибирьт байдаг. Дэлхийн хамгийн том газрын тосны экспортлогч, газрын тосныхоо ихэнхийг ЕХ-д нийлүүлдэг	16 тэрбум баррель газрын тосны нөөцтэй бөгөөд 1993 оноос газрын тос импортлогч орон болсон. Газрын тосны үйлдвэрлэл 2008 онд 190 сая тоннд хүрсэн ба 179 сая тонн газрын тосыг импортлож, 4 сая тонныг экспортолсон байна. Газрын тосны импортын хамаарал 2020 он гэхэд 65.5 хувь хүрнэ гэсэн тооцоо ¹²⁴ байна.	Газрын тос, байгалийн хийн нөөцгүй бөгөөд АНУ-ын дараа дэлхийн хоёрдогч том газрын тосны импортлогч улс юм. Газрын тосны хэрэглээгээрээ э АНУ, Хятадын дараа гуравт ордог ¹²⁵ .	Газрын тосны нөөцгүй орон бөгөөд эрчим хүчнийхээ 50 хувийг газрын тосоор хангадаг. Тиймдээ ч өдгөө газрын тосны тавдагч импортлогч ¹²⁶ болж газрын тосны хэрэглээгээрээ дэлхийд долоод жагсаж байна.
3	Эрчим хүч	Дотоодын эрчим хүчний хэрэглээнийхээ 55 хувийг байгалийн хий, 19 хувийг газрын тос, 16 хувийг нүүрс, 5	Эрчим хүчнийхээ 70 хувийг нүүрсээр, 20 хувийг газрын тос, 6 хувийг атомын	Эрчим хүчнийхээ 49 хувийг газрын тос, 20 хувийг нүүрс, 14 хувийг байгалийн хий, 13 хувийг	Эрчим хүчний хэрэглээнийхээ үлдсэн 24 хувийг нүүрс, 14 хувийг атомын энерги, 12 хувийг

¹²⁴ <http://www.china.cippe.net/news/11710.htm>¹²⁵ <http://www.eia.doe.gov/emeu/cabs/Japan/Full.html>¹²⁶ <http://www.eia.doe.gov/emeu/cabs/South Korea/Full.html>

		хувийг атомын инергизэр хангаж байна.	энерги, 3 хувийг байгалийн хийгээр хангаж байна.	атомын энергизэр хангадаг байна.	байгалийн хийгээр хангадаг байна.
--	--	---	---	---	--

Монгол нь алт, зэс, нүүрс болон бусад байгалийн баялагийн их хэмжээний нөөцтэй орон. Монголд одоо илрүүлээд байгаагаар ашигт малтмал эрдэс баялгийн 80 гаруй төрлийг тогтоосон 6000 гаруй орд газартай байна. Нүүрсний нөөц одоогоор 152 тэрбум тонноор үнэлэгдэж байна. 2008 онд 8.3 сая тонныг үйлдэрлэж, 6.5 сая тонныг хэрэглэн, үлдсэнийг экспортод гаргасан байна. Таамаг нөөцөөр 5 тэрбум баррель газрын тос, 1.4 сая тонн ураны нөөцтэй байна.

Энэхүү байгалийн нөөцүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж улс орны хөгжил дэвшлийг хангах зорилтын хүрээнд “Стратегийн ордуудыг ашиглах тухай”, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” зэрэг эрх зүйн баримтуудыг баталж хэрэгжүүлэх ажил эхлээд байна. Дэлхийн хөгжингүй орнуудын зүгээс ч Монголыг сонирхож, Монголын уул уурхайд хөрөнгө оруулалт хийхийг эрмэлзэж эхэллээ. Монгол улс ч хөрш хоёр орны хөрөнгө оруулалтаас гадна гуравдагч зах зээлд бүтээгдэхүүнээ гаргах, байгаль орчинд ээлтэй өндөр технологийг нэвтрүүлж чадах орнуудын хөрөнгө оруулалтыг дэмжихээ зарласан. Тухайлбал төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын 1.2.1.2-д “ОХУ, БНХАУ-ын төмөр замын тээврийн сүлжээг ашиглан гуравдагч зах зээлд хүрэх худалдаа, тээврийг хөнгөвчилсөн шинэ замнал /маршрут/-ыг бий болгон далайн боомтуудад гарцтай болох”¹²⁷ гэсэн бол 2.2.4-д “ашигт малтмалын гаралтай түүхий эд, түүнээс боловсруулан гаргах бүтээгдэхүүнийг голлон худалдан авагч нь ОХУ, БНХАУ, Ази, Номхон далайн орнууд болон Европын холбоо байх”¹²⁸ гээд далайд гарцгүй манай улсын гадаад худалдаа, хамтын ажиллагаа өргөжиж, уул уурхайн бүтээгдэхүүнийг ОХУ-д болон гуравдагч орнуудад ОХУ-ын Алс Дорнодын боомтыг ашиглан экспортлох боломжийг бий болгохыг эрмэлзэнэ¹²⁹ гэсэн байна.

Хэрэглээ багатай, баялаг нөөцтэй Монгол орны хажууханд 100 хувь импортоос хамаарч буй асар том хэрэглэгч Япон, Өмнөд Солонгос болон хэрэглээ нь хурдтай өсөж буй Хятад байгаа нь хангалттайгаар барахгүй дэд бүтцийн асуудлаа шийдвэрлэж чадвал ойрхон дөт зах зээл бидэнд байна. Үүнийг бид яаж ажил хэрэг болгох вэ?

¹²⁷ Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай. УИХ-ын тогтоол.

2010 он

¹²⁸ Мөн тэнд

Монгол улс ОХУ, Хятадтай хиллэдэг ч зүүн хилээс Хятадаар дамжин Солонгосын хойг хүртэл 1000 км-ийн зайтай, цааш Японтой холбогдох дөт холбогдох боломжтойн дээр Зүүн Хойд Азийн бүс нутаг нь Төв Ази, Зүүн Өмнөд Ази, Ойрхи Дорнодыг бодвол террорист хандлаг үйлдэгдэх магадлал харьцангуй багатай, далайн тээвэрлэлтийн аюулгүй байдлыг улс орнуудын засгийн газраас хянах боломжтой зэрэг давуу талтай.

Монгол улсын хувьд засгийн газраас “Мянганы зам” төсөл, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” зэрэг бодлогын баримт бичгүүдийг гарган хэрэгжүүлэх ажил ид өрнөж байна. Зүүнээс баруун, хойноос урагш огтолцсон авто замуудыг тавьж байна. Төмөр замын хувьд хойноос өмнө босоо чиглэлийн ганц шугамтай байгаа ч дотоодын хөндлөн зам тавих асуудлыг УИХ-аар батлуулж хэрэгжүүлэх ажилдаа ороод байгаа. Уул уурхайн хөрөнгө оруулалтыг даган дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзвэл тээвэрлэлтийн асуудал давхар шийдэгдэнэ.

Байгалийн баялаг, эрчим хүчний нөөцөө ашиглахад Монгол улс дангаараа хүч хомсдох тул гадаадын хөрөнгө оруулалт, өндөр технологийг ашиглах шаардлага гарах бөгөөд тэр дундаа Зүүн Хойд Азийн орнуудаас тусламж, дэмжлэг авах нь гарцаагүй тул хамтран эзэмшиж ашиглах явцдаа үнийн бодлогыг зохицуулах, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлах, цаашид эрчим хүчний интеграцийг дагаад үнийн механизмыг бүрдүүлэх боломж байж болох юм.

Эцэст нь дүгнэхэд Зүүн Хойд Азид Монгол улс байгалийн арвин их нөөцөө олборлон экспортолж энэ бүс нутгийн орнуудад зах зээлийн чөлөөт эдийн засгийн тогтолцоо, ардчилсан нээлттэй улс төрийн орчин, хууль эрх зүйн төлөвшин буй орчин, газарзүйн байршлын таатай давуу тал болох аюулгүй тээвэр, өрсөлдөх чадвар бүхий тогтвортой үнэ зэргийг санал болгож чадах дүр төрх бүрдэж байна.

Нөгөө талаас эрчим хүч, нүүрс, газрын тос, уран байгалийн бусад баялгийн өндөр хэрэглээтэй Хятад, Япон, Өмнөд Солонгос улсууд эрчим хүчний хангамжаа боломжит үнээр, тасалдалгүй байнга хангаж, аюулгүй байдлын үүднээс эрчим хүчний импортоо олон сувагтай болгох сонирхолтой.

Дээр дурьдан буй угталцсан эрх ашгууд Зүүн Хойд Азийн орнуудтай Монгол улс цаашид хамтын ажиллагааг хөгжүүлэх хангалттай үндэслэл болж байна.

Abstract

The Northeast Asia is third significance region for Mongolian geostrategic and foreign policy. The Northeast Asian region has been getting more global attention, due to the rapid development of economies such as China and South Korea resulting in enhanced coordination and cooperation among countries, mainly in economic affairs. On the other hand, this region is considerably rich in political, economic, ethnic and religious diversity and conflict between countries (North and South Korea). Because of

these reasons major changes in the security environment have yet to emerge and long-standing issues of territorial rights and reunification continue to plague the region. This article purpose is to study the external political and economic conditions of Mongolia in the Northeast Asian region.

Ашигласан материал

1. Монгол улсын гадаад бодлогын хөх ном. УБ., 2006
2. Ц.Батбаяр. Монгол ба Япон ХХзууны эхэн хагаст. УБ.,1998
3. Д.Баярхүү. Евразийн геополитик, олон улсын харилцаа: өнгөрсөн, одоо, ирээдүй. УБ., 2005
4. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал. УБ хот
5. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай. УИХ-ын тогтоол. УБ., 2010 он
6. Стратеги судлал сэтгүүл. № 45(1/2009), №46(2/2009), №47(3/2009), №48(4/2009), №49(1/2010), №50(2/2010). Стратегийн судалгааны хүрээлэн.
7. Defense of Japan 2009. Ministry of Defense, Japan.